

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРААС 2023 ОНД ЗОХИОН
БАЙГУУЛАН ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ АЖЛУУД**

СЭДЭВ 1. ҮНДСЭН ХУУЛИЙН ӨӨРЧЛӨЛТ	3
Асуудал 1. Улсын Их Хурлын гишүүдийн тоо	3
Асуудал 2. Санал гээгдэлт – Олон намын төлөөлөл	3
Шийдсэн:	4
Ач холбогдол	4
СЭДЭВ 2. УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ	5
Асуудал 1. Улс төр дэх жендэрийн эрх тэгш байдал	5
Асуудал 2. Гадаад дахь монголчууд	5
Шийдсэн:	5
Ач холбогдол	5
СЭДЭВ 3. ХҮНИЙ ЭРХ	6
Асуудал. Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдал	6
Шийдсэн:	6
Ач холбогдол	6
СЭДЭВ 4. ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙГ НЭГТГЭХ, ЦӨӨЛӨХ	8
Асуудал. Хэт олон төрийн өмчит компани	8
Шийдсэн:	8
Ач холбогдол	8
СЭДЭВ 5. ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ, ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ШИНЭЧЛЭЛ	9
Асуудал 1. Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах	9
Шийдсэн:	9
Ач холбогдол	10
Асуудал 2. Төрийн өмчит компанийн ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалт ..	10
Шийдсэн:	10
Ач холбогдол	11
СЭДЭВ 6. “ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН БЭТ	12
Асуудал. Нүүрсний үнэ, тээвэр, оффтейк гэрээ	12
Шийдсэн:	12
Ач холбогдол	12
СЭДЭВ 7. ПРОЦЕССЫН ДАХИН ИНЖЕНЕРЧЛЭЛ	14
Асуудал. Төрийн үйлчилгээ иргэдийн хэрэгцээ шаардлага, орчин үеийн нөхцөлд нийцэн хангалттай сайжрахгүй байна	14
Шийдсэн:	14
Ач холбогдол	14
СЭДЭВ 8. ДОТООДЫН АГААРЫН ТЭЭВЭР	15
Асуудал. Дотоодын нислэгийн үнэ тариф хэт өндөр байсан	15

Шийдсэн:	15
Ач холбогдол.....	15
СЭДЭВ 9. ШҮҮР АЖИЛЛАГАА.....	16
Асуудал	16
Шийдсэн:	16
Ач холбогдол.....	16
СЭДЭВ 10. СУДАЛГААНЫ НЭГДСЭН САН.....	17
Асуудал. Төрд хийгдсэн судалгаа, шинжилгээний ашиглалт хангалтгүй.....	17
Шийдсэн	17
Ач холбогдол.....	17
СЭДЭВ 11. ОРАНО	18
СЭДЭВ 12. ДОПИНГ	19
Асуудал. Дэлхийн допингийн эсрэг байгууллагаас Монгол Улс олимпод цагаан тугийн дор орох эрсдэлтэй байгааг сануулсан.....	19
Шийдсэн:	19
Ач холбогдол.....	20

СЭДЭВ 1. ҮНДСЭН ХУУЛИЙН ӨӨРЧЛӨЛТ

Асуудал 1. Улсын Их Хурлын гишүүдийн тоо

Улсын Их Хурлын гишүүдийн тоо 76 хүн буюу цөөн байгаа нь эрх мэдэл хэт төвлөрөх, нэг хүнд хариуцлага, ачаалал нэмэгдэх нөхцөл байдлыг бий болгосон. Тухайлбал УИХ-ын гол хэлэлцдэг хуулийн нэг улсын төсөв байдаг. 2022 оны төсөв 18.2 их наяд байсан бөгөөд нэг УИХ гишүүнд ногдох төсвийн хэмжээ 239 тэрбум, хөрөнгийн зардал 5.1 их наяд буюу нэг гишүүнд 67,1 тэрбум төгрөгт хүрсэн. Цаашлаад 30 жилийн хугацаанд мажоритар сонгуулийн үр дүнд иргэд, сонгогчдод таалагдахыг эрмэлзсэн, нийгэм, эдийн засгийн ач холбогдол багатай, баялгийг үрэн таран хийсэн олон үр ашиггүй шийдвэрүүд гарч байсан нь улс орны хөгжлийг хойш татаж байсан.

Дахин сонгогдохын тулд иргэдэд таалагдах, богино хугацаанд буюу 4 жилд үр дүнгээ өгөх ажлуудад анхаарал хандуулж, урт хугацааны стратеги зорилтууд хэрэгжих боломжгүй болох эрсдэлийг нэмэгдүүлсэн.

Асуудал 2. Санал гээгдэлт – Олон намын төлөөлөл

Одоогийн парламентын гишүүдийн тоо, сонгуулийн мажоритар систем нь иргэдийн санал гээгдэх буюу бага саналаар УИХ-д олонх болох нөхцөл болсон.

Монгол Улсын 2020 оны УИХ-ын сонгуулиар МАН-аас нэр дэвшсэн гишүүд нийт санал өгсөн иргэдийн 45 хувийн саналыг авсан боловч 62 суудал буюу 82 хувиар ялалт байгуулсан. Хэрвээ цэвэр холимог системээр сонгууль хийгдсэн буюу 2020 оны намын нэр дэвшигчдэд өгсөн саналыг намд саналаа өгсөн гэж хийсвэрээр тооцож үзвэл 45 хувьд 34 гишүүн ногдохоор байгаа ба Улсын Их Хуралд дор хаяж 6 намын төлөөлөл байхаар тооцоо байна.

	Авсан санал	Эзлэх хувь	Хувиар тооцсон суудлын тоо	Сонгуули	Сонгуулийн үр дүн хувиар	Зөрүү
Монгол Ардын нам	665,439	45%	34	62	81.6%	36.4%
Ардчилсан нам	364,913	25%	19	11	14.5%	-10.3%
Бие даан нэр дэвшигч	123,969	8%	6	1	1.3%	-7.1%
Та бидний эвсэл	116,851	8%	6	1	1.3%	-6.6%
Шинэ эвсэл	78,917	5%	4	-	0.0%	-5.4%
Зөв хүн электорат эвсэл	78,007	5%	4	1	1.3%	-4.0%
Сахигтун! Үндсэн хуулийн 19 эвсэл	14,319	1%	1	-	0.0%	-1.0%
Монголын Ногоон нам	8,327	1%	0	-	0.0%	-0.6%
Ард Түмнээ Хайрлая нам	6,181	0%	0	-	0.0%	-0.4%
Ард Түмний Олонхийн Засаглал нам	4,760	0%	0	-	0.0%	-0.3%
Зон Олны нам	3,193	0%	0	-	0.0%	-0.2%
Их Эв нам	2,059	0%	0	-	0.0%	-0.1%
Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч нам	1,828	0%	0	-	0.0%	-0.1%
Гэр хороолол хөгжлийн нам	1,564	0%	0	-	0.0%	-0.1%
Хөгжлийн Хөтөлбөр нам	1,257	0%	0	-	0.0%	-0.1%
Ард Түмний нам	1,111	0%	0	-	0.0%	-0.1%

Эх Орончдын Нэгдсэн нам	224	0%	0	-	0.0%	0.0%
Дэлхийн Монголчууд нам	197	0%	0	-	0.0%	0.0%
Дүн	1,473,114	100%	76	76	100%	0.0%

УИХ-ын 2020 оны сонгуулийн үр дүнгээс харахад 36 хувь буюу 536 мянган иргэний санал гээгдсэн гэсэн үг юм.

Шийдсэн:

УИХ гишүүдийн тоог 126 болгож, сонгуулийн холимог тогтолцоог нэвтрүүлсэн. 2022 оны 6 дугаар сард улс төрийн 24 нам санал нэгдэн Үндсэн хуульд өөрчлөлт оруулах шаардлагын тухай Тунхаг бичиг гаргасан. Улмаар Засгийн газраас Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг **2023.05.03-ны өдөр УИХ-д өргөн барьж, улмаар 2023.05.31-ний өдөр** нийт гишүүдийн 97%-ийн саналаар батлагдсан.

Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг “Улсын Их Хурал нэг танхимтай, **нэг зуун хорин зургаан гишүүнтэй** байна. Улсын Их Хурлын сонгуулийг **сонгуулийн холимог тогтолцоогоор** явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно” хэмээн өөрчлөн найруулсан.

Ач холбогдол

- Парламентийн засаглал, үндэсний дархлааг бэхжүүлэх;
- Нэгээс хоёр намын хэт давамгайллыг арилгах;
- Төлөөлөх чадварыг сайжруулах;
- Тойрогт суурилсан бодлогын алдааг залруулах – Бодлогын намуудыг төлөвшүүлэх нөхцөл бүрдсэн.

Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагын гишүүн 37 улсын 8 нь холимог тогтолцоог /Япон, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс г.м/, 24 нь хувь тэнцүүлэх тогтолцоог /Швед, Нидерланд г.м/ улс, 5 нь /Америкийн Нэгдсэн Улс, Англи, Франц, Канад, Австрали/ нь сонгуулийн олонхийн тогтолцоог хэрэглэдэг.

СЭДЭВ 2. УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Асуудал 1. Улс төр дэх жендэрийн эрх тэгш байдал

Хүйсийн тэнцвэртэй төлөөлөл алдагдсан. Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, 2-т “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.”, Арван зургадугаар зүйлийн 11-т “улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй ...” гэж тус тус заасан.

Монгол Улсын хүн амын 51 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Гэвч УИХ-д 2012 онд 11, 2016, 2020 онд тус тус 13 эмэгтэй гишүүн буюу хамгийн ихдээ 17 хувийг эмэгтэй гишүүд бүрдүүлж ирсэн.

Асуудал 2. Гадаад дахь монголчууд

Гадаадад ажиллаж амьдарч байгаа монголчуудын тоо жил ирэх тусам нэмэгдэж байна.

2023 оны байдлаар хилийн чанадад ажиллаж, амьдарч байгаа иргэд 200 орчим мянга хүрч байна. Эдгээр иргэдийн улс төрийн эрхийг эдлүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна. Цаашлаад гадаад дахь монголчуудын улс төр, нийгэм, эдийн засгийн эрхийн хэрэгжилтийг хангах, тэдний ажиллаж амьдрах нөхцөл байдлыг сайжруулах талаар УИХ дээр яригдах нь зайлшгүй асуудал юм.

Шийдсэн:

2024 оны ээлжит сонгуулиар нийт нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь нь, 2028 оны ээлжит сонгуулиар 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байх, цаашилбал нам, эвсэл жагсаалтаар нэр дэвшүүлэхдээ 1:1 хүйсийн харьцаатай байх зохицуулалтыг тусгасан. Түүнчлэн гадаад улсад байгаа сонгогч сонгуульд саналаа өгөх эрхийг нээлттэй болгосон.

Эмэгтэйчүүдийн хувь оролцоог нэмэгдүүлэх асуудлаар олон удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Ач холбогдол

Аткесон, Каррилло нарын судлаачид хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл нэмэгдэх тусам иргэдийн, тэр тусмаа эмэгтэйчүүдийн төрд итгэх итгэл, төрийг хүлээн зөвшөөрөх байдал нэмэгддэг болохыг олж тогтоосон байдаг. Цаашилбал эмэгтэйчүүд улс төрд олноороо оролцсоноор улс төрийн манлайллын хэв маягийг илүү кооператив буюу харилцан бие биеэ ойлгох, хамтран ажиллах шинж чанартай болгодог гэж үздэг.

Харин эрчүүд давамгайлсан улс төрд голдуу ширүүн өрсөлдөөн болон хатуу шатлан захирах ёс (hierarchy) дээр суурилсан манлайллын хэв маяг давамгайлдаг байна. Олон улсад хийгдсэн хэд хэдэн судалгаагаар эмэгтэй улстөрчид гэр бүл, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн тулгамдсан асуудлуудад эрэгтэй улс төрчдөөс илүү ач холбогдол өгдөг нь батлагдсан байна

СЭДЭВ 3. ХҮНИЙ ЭРХ

Асуудал. Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдал

Өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд Монгол Улс хүний эрхийг хангах, эрх чөлөөг дээдлэх тал дээр багагүй амжилт гаргасан нь олон улс, тэр дундаа Ази тивдээ өндрөөр үнэлэгддэгийг дурдах нь зүйтэй юм.

Улс орнуудын хөгжил, хүний эрх, эрх чөлөө, ардчиллын нөхцөл байдалд үнэлгээ өгч эрэмбэлдэг олон улсын судалгаа, шинжилгээний байгууллагуудаас гаргадаг индексээр Монгол Улс дараах үзүүлэлттэй байна:

- Эрх зүйт ёсны индексээр 2023 оны байдлаар 142 орноос 64 дүгээрт;
- Хүний эрх чөлөөний индексээр 2020 оны байдлаар 165 орноос 51 дүгээрт;
- Авлигын төсөөллийн индексээр 2022 оны байдлаар 180 орноос 116 дугаарт;
- Хэвлэлийн эрх чөлөөний индексээр 2023 оны байдлаар 180 орноос 88 дугаарт;
- Хүүхдийн эрхийн индексээр 2023 оны байдлаар 193 орноос 93 дугаарт;
- Жендэрийн тэгш бус байдлын индексээр 2021 оны байдлаар 195 орноос 76 дугаарт;
- Хүний хөгжлийн индексээр 195 орноос 96 дугаарт;
- Либерал ардчиллын индексээр 2023 оны байдлаар 179 орноос 77 дугаарт тус тус эрэмбэлэгдэж байна.

Энэ мэтчилэн олон улсын байгууллагуудаас хийдэг төрөл бүрийн индексээр бид хаана байгаагаа хэмжиж ирсэн.

Тэгвэл өнгөрсөн онд 21 аймаг, нийслэлийн нутаг дэвсгэр дэх хүний эрхийн нөхцөл байдал, зөрчил ямар байгааг баримтжуулан, арга хэмжээ авч сайжруулахын тулд анх удаа Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлыг үнэлэх, шаардлагатай арга хэмжээг тодорхойлох шаардлага үүссэн байсан.

Шийдсэн:

Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлын үнэлгээг анх удаа гүйцэтгэсэн.

Монгол Улс хүний эрх, эрх чөлөөний байдлаар дэлхийн 180 орноос 29.6 оноо авч 155 дугаар байрт, Ази номхон далайн 25 орноос 19 дүгээр байрт эрэмбэлэгдсэн байна. Уг индексийн хувьд “хамгийн бага оноо авсан улсууд нь тогтвортой байдлаас илүүтэй эдийн засгийн өсөлтийг чухалчилсан эсвэл иргэний эмх замбараагүй байдал болон бусад хямралтай тэмцэж буй орнууд байна” гэдгийг илтгэлдээ цохон тэмдэглэсэн байна.

Ач холбогдол

Орон нутагт хүний эрхийн төлөв байдал, түүний хэрэгжилт харилцан адилгүй байгаа нь цаашид Үндэсний хөтөлбөрөө шинэчилж батлах, түүний хэрэгжилтийг үнэлэхдээ өөрсдийн онцлогт тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, дотоодын индекс тогтоох нь чухал байгааг харууллаа.

Иймд цаашид гагцхүү төрөөр хязгаарлахгүй, мэргэжлийн холбоо, хүний эрх хамгаалагч, мэргэшсэн шинжээч, байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөл зэрэг бүх талууд орон нутгийн хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулахад ямар зүйлээс эхлэх, юунд түлхүү анхаарах шаардлагатай байгааг олж тогтоосон.

СЭДЭВ 4. ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙГ НЭГТГЭХ, ЦӨӨЛӨХ

Асуудал. Хэт олон төрийн өмчит компани

ЗГХЭГ, Яамдын харьяанд 2022 оны 10 дугаар сарын байдлаар 130 хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байсан. Тэдгээрийн цөөнгүй нь ижил чиглэлийн үйл ажиллагаа явуулахаас гадна зарим компанийн үйл ажиллагаа зогсонги байдалд орсон, байгуулагдсанаасаа хойш үр дүнтэй ажил хийгээгүй байсан.

Шийдсэн:

2022 оны 10 дугаар сараас хойш 34 хуулийн этгээдийн үйл ажиллагааг нэгтгэх, хаах арга хэмжээ авч 96-д хүргэсэн.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн 39 компаниас 12-ыг татан буулгах, нэгтгэх арга хэмжээ авсан:

- “Эрдэнэт ойл” ХХК;
- “Шим технолоджи” ХХК;
- “Эрдэнэс силвер ресурс” ХХК;
- “Газрын ховор элементийн төсөл”;
- “Эрдэнэс стийл” ХХК;
- “Эрдэнэс ашид” ХХК;
- “Шивээ сервис” ХХК;
- “Эрдэнэс шивээ энерги” ХХК;
- “Эрчим хүчний шивээ энерги төсөл”;
- “Эрдэнэс ассет менежмент” ХХК;
- “Эрдэнэс газ төслийн нэгж”;
- “Эрдэс баялгийн бирж” ХХК;
- “Эрдэнэс Баянбогд” ХХК.

Түүнчлэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяанд үйл ажиллагаа явуулж байсан “Засгийн газрын хэвлэх үйлдвэр” аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, “Төрийн ордны амралт үйлчилгээний цогцолбор” улсын төсөвт үйлдвэрийн газруудыг татан буулгаж, “Засгийн газрын автобааз” улсын төсөвт үйлдвэрийн газрыг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болгон өөрчлөн зохион байгуулж, үйл ажиллагааны орлогоороо өөрийгөө санхүүжүүлдэг болгосон.

Мөн автозамын засвар ашиглалтын 20 компанийг нэгтгэсэн.

Ач холбогдол

“Эрдэнэс монгол” нэгдлийн харьяаны 39 компанийг 27 болгон цөөлж, ТУЗ-ийн 269 гишүүн ажиллаж байсныг 66 болгож бууруулсан.

Автозамын засвар ашиглалтын 20 АЗЗА компанийн ТУЗ-д нийт 72 хүн ажиллаж байсныг 9 болгон бууруулсан. Энэ мэтчилэн үр ашиггүй байсан компаниудыг татан буулгах эсвэл нэг салбар, чиглэлд үйл ажиллагаа явуулдаг боловч өөр өөр зорилготой, давхардсан чиг үүргийг нэгтгэснээр зөвхөн ТУЗ-ийн хувьд жилд 2-3 тэрбум төгрөгийн зардал хэмнэх, цаашлаад захиргааны шинжтэй ажлууд болон машин механизмын ашиглалт сайжирч ихээхэн хэмжээний зардлын хэмнэлт үүсэх нөхцөл бүрдсэн.

СЭДЭВ 5. ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ, ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ШИНЭЧЛЭЛ

Асуудал 1. Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тайлан хүргүүлдэг 98 компанийн нэгтгэсэн үзүүлэлтээр 2022 онд хөрөнгийн өгөөж 3.5 хувь, эздийн өмчийн өгөөж 5.5 хувь байна. Харин “Эрдэнэс таван толгой” ХК болон “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ашгийг хасаж тооцвол үлдэх 96 хуулийн этгээдийн хөрөнгийн өгөөж 0.4 хувь, эздийн өмчийн өгөөж 0.7 хувьтай байна.

Түүнчлэн 98 этгээдийн 53 нь алдагдалтай ажилласан байдаг.

Салбар	№	2022 ашиг	Хөрөнгийн өгөөж	Нийт ажиллагсадын тоо
Байгаль орчин аялал жуулчлал	3	(485,866)	-6.2%	41
Банк санхүүгийн салбар	6	212,906,428	2.5%	4,146
Барилга хот байгуулалт	3	(3,701,405)	-0.7%	1,052
Биеийн тамир спорт	2	(397,399)	-0.8%	40
Гадаад харилцаа	1	540,608	1.4%	167
Зам тээвэр	28	(41,996,716)	-0.9%	19,552
Мэдээлэл харилцаа хоблоо	4	2,821,041	1.0%	3,072
Соёл урлаг	1	52,306	1.2%	15
Уул уурхай	16	114,330,246	0.7%	5,517
ХХАА хөнгөн үйлдвэр	3	991,718	3.7%	284
Эрчим хүч	29	(151,668,657)	-3.7%	11,656
Эрдэнэс Тавантолгой ХК	1	1,110,525,487	5.9%	4,504
Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	1	831,164,092	14.2%	6,850
НИЙТ	98	2,075,081,884	3.5%	56,896

Энэ нь Монгол Улсын төрийн өмчит компанийн дийлэнх нь орлого, зарлагын хувьд тэнцсэн буюу үр ашиггүй, засаглал менежментийг сайжруулах шаардлагатай байгааг илтгэж байсан.

Түүнчлэн уул уурхайн салбарын компаниудын засаглалыг сайжруулах, улмаар гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2007 онд байгуулагдаж байсан “Эрдэнэс монгол” компанийн үйл ажиллагаа зогсонги байдалд ороод байсан.

Шийдсэн:

“Эрдэнэс монгол” компанийн ажилтан албан хаагчдыг нээлттэй сонгон шалгаруулалт хийсэн.

Иймд “Эрдэнэс монгол” компанийг анхны үүсгэн байгуулагдсан зорилгын дагуу төрийн өмчит уул уурхайн бүх компаниудыг нэгдсэн удирдлагад оруулах, засаглал, үйл ажиллагааг сайжруулах шинэчилсэн зохион байгуулалтыг хийсэн.

Тиймээс ч чадварлаг хүний нөөц хамгийн нэн тэргүүний асуудал байсан тул нээлттэй сонгон шалгаруулалтыг богино хугацаанд хийж хүний нөөцийг бүрдүүлэн авахыг компанийн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагад санал болгосон.

Улмаар 2023 оны 1 дүгээр сард 88 ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт явуулж, 76 хүн шалгарсан байдаг. Өнгөрсөн сарын байдлаар сонгон шалгаруулалтаар ажилд орсон хүмүүсээс 70 нь ажлаа хийж байна гэсэн мэдээлэл авсан.

Цаашид төрийн өмчийн компаниудын ажлын байрыг нээлттэй, тодорхой үе шаттай зохион байгуулах ажлыг жишиг болгох зорилгоор Засгийн газраас 2023 онд “Төрийн өмчийн хуулийн этгээдийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах нийтлэг журам”-ыг батлаад байна.

Ач холбогдол

- Улс төрийн нөлөөллийг багасгах;
- Нэгдсэн удирдлагын тогтолцоо бүрдүүлэх;
- Шийдвэр гаргалтыг түргэсгэх;
- Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт татах боломжийг нэмэгдүүлэх.

Асуудал 2. Төрийн өмчит компанийн ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалт

Төрийн өмчит компаниудын үр ашигт байдал сул, засаглал менежментийн хувьд хоцрогдмол, ил тод байдал хангалтгүй байж ирсэн. Үүнтэй холбоотойгоор төрийн хөрөнгө үргүй зарцуулагдах, ашиг сонирхлын зөрчилд автах зэрэг сөрөг үр дагаврууд гарсаар байсан.

Тухайлбал төрийн өмчит компаниудын удирдах зөвлөлд төрийг төлөөлж томилогдох гишүүн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу доорх 3 шаардлагыг хангах ёстой:

1/тухайн хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үүргийг гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, чадвартай;

2/тухайн хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байхад ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй байх;

3/төрийн захиргааны албан хаагч болон энэ зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасны дагуу тогтоосон этгээдийн ажилтан байх.

Эдгээр шаардлагуудыг тавих боловч тодорхой, ил тод сонгон шалгаруулалтыг журамлаагүйгээс ТУЗ-ууд мэргэжлийн бус байх, түүнээс улбаатайгаар асуудал зөрчил үүсэх томоохон нөхцөл бүрджээ гэж дүгнэж болохоор байна.

Шийдсэн:

ТУЗ-ийн гишүүн шалгаруулах журмуудыг шинэчлэн баталж мөрдүүлж эхлэсэн.

Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоол “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”

Засгийн газрын 2023 оны 85 дугаар тогтоол “Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”

Дээрх журмуудын дагуу төрийн өмчит компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр сонгодог болгосноос гадна нэмэлт шаардлагуудыг тавьж эхэлсэн. Тухайлбал:

- Эрүүгийн хуульд заасан эдийн засгийн, авлигын, өмчийн эсрэг гэмт хэрэгт шүүхийн шийдвэрээр гэм буруутай нь тогтоогдож байгаагүй байх;
- Сүүлийн дөрвөн жил улс төрийн намын ажилтан, сонгуульт удирдах албан тушаал хашиж байгаагүй, эсхүл улс төрийн албан хаагчаар ажиллаж байгаагүй байх;
- Эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан хуулийн этгээд нь дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон нь түүнээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй нь нотлогдсон; гэх мэт.

Ач холбогдол

Компанийн засаглалын гол хэсэг буюу хяналтын гол механизм болох төлөөлөн удирдах зөвлөлийн чадавх сайжирч, үр ашиг менежментийн түвшин сайжирна гэж үзэж байна.

СЭДЭВ 6. “ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН БЭТ

Асуудал. Нүүрсний үнэ, тээвэр, оффтейк гэрээ

“Эрдэнэс тавантолгой” ХК-д Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх хүрээнд 2022 оны төгсгөл гэхэд 500 сая ам.доллар татан төвлөрүүлэх чиглэлийг өгч, улмаар компанийн үйл ажиллагаанд үүссэн доголдлыг залруулах арга хэмжээ авах шаардлагыг өгсөн. Гэвч үүрэг чиглэлийн биелэлтийг хүлээн авахгүй, үйл ажиллагаагаа залруулахгүй байсан.

Шийдсэн:

Компанийн бүтэц зохион байгуулалтыг оновчтой тогтоож, шинэчлэх, шаардлагатай бол нэгжийн удирдлага, холбогдох албан тушаалтныг томилж, чөлөөлөх;

Технологийн тухайлсан дүрэм, үйлдвэрлэлийн аюулгүй байдал, ослоос сэргийлэх дүрэм журмыг нарийвчлан тогтоож, зөрчигчдөд зохих хариуцлага хүлээлгэх;

Тавантолгойн нүүрсний ордоос нүүрс ачих, тээвэрлэх, худалдан борлуулах, хил нэвтрүүлэх бүхий л шатанд шаардлагатай арга хэмжээг тухай бүрд нь авч хэрэгжүүлэх зорилгоор “Эрдэнэс тавантолгой” ХК-д онцгой дэглэм тогтоосон.

Ач холбогдол

- **Ил тод байдлыг хангах үүднээс нууцад хамруулсан төслийн гэрээнүүдийг ил тод болгов**

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 449 дүгээр тогтоолын дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-д холбогдох төрийн нууцын зэрэглэлтэй 7 гэрээг нууцаас гаргасан. Улмаар, “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалттай холбоотой 2 гэрээ, “Богдхан” төмөр замын бүтээн байгуулалттай холбоотой 3 гэрээ, Загийн усны хоолойн болон далд уурхайн бүтээн байгуулалттай холбоотой тус бүр 1 гэрээг нууцаас гарган, компанийн цахим хуудсаар дамжуулан олон нийт нээлттэй танилцах боломжоор хангасан;

- **Нүүрсийг биржээр, хил нөхцөлөөр борлуулж, нүүрсний үнэ, борлуулалтыг нэмэгдүүлсэн**

Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нүүрсний нээлттэй цахим арилжааг 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдөр анх удаа зохион байгуулж эхэлсэн.

Компанийн түүхэн 12 жилийн хугацаанд 212 мянган тонн сул коксжих нүүрс борлуулж байсан бол биржээр 74.3-124.6 ам доллароор 2.8 сая тонн энэ төрлийн нүүрсийг борлуулсан. Нүүрсийг хил нөхцөлөөр, биржээр борлуулснаар коксжих нүүрсний үнэ тонн тутамд 80-115 ам.доллар байсныг 119.1-182.1 ам.долларт, эрчим хүчний нүүрсний үнэ тутамд 37 ам.доллар байсныг 58.7-73.3 ам.долларт хүргэсэн;

- **Нүүрс худалдах, худалдан авах гэрээний нөхцөлийг өөрчлөн, уурхайн ам нөхцөлөөс, хил нөхцөлд шилжүүлэв**

Онцгой дэглэм тогтоох үед “Эрдэнэс Тавантолгой” ХК нь нийт **178 нүүрс худалдах** гэрээтэй байсан бөгөөд үүнээс **уурхайн ам нөхцөлтэй 133 гэрээ**, FCA-Гашуунсухайт нөхцөлтэй 7, оффтэйк 4 гэрээтэй холбоотой 38 дэд гэрээ байсан. 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар **уурхайн ам нөхцөлтэй 14 нүүрс гэрээтэй** байгаагаас FCA-уурхайн ам нөхцөлтэй 11 гэрээ, оффтэйк гэрээтэй холбоотой 3 гэрээ байна.

- **Уулын ажил гүйцэтгэх зардлыг бууруулав**

Нэг м³ уулын ажлын зардал 12,945 төгрөг байсныг 1,445 төгрөгөөр бууруулан 11,500 төгрөг, нэг м³ өрөмдлөг тэсэлгээний ажлын зардал 2,000 төгрөг байсныг 802 төгрөгөөр бууруулан 1,198 төгрөг, нэг тонн нүүрс ачилтын зардал 1,763 төгрөг байсныг 165 төгрөгөөр бууруулан 1,598 төгрөг, мөн 17 төрлийн ажлын төсвийг бууруулан тендер зарласнаар 792.6 сая төгрөг, **нийт 363.2 тэрбум төгрөгийн зардлын хэмнэлт** хийх нөхцөл бүрдүүлсэн.

- **Компанийн өр төлбөрийг барагдуулж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэв**

Дээр дурдсан онцгой дэглэм тогтоох үеийн санхүүгийн үзүүлэлтийг эрс сайжруулж, худалдан авагчдад өгөх өр төлбөр 582 сая ам. доллар байсныг 2023 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр **бүрэн төлж барагдуулав**.

1.7 их наяд төгрөгийн мөнгөн хөрөнгийн **дутагдалтай** байхаар **баталсан төсвийг** сайжруулж, **385 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийн эерэг үлдэгдэлтэй** гаргасан.

- **Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудит**

“Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 457 дугаар тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудит хийлгэхээр шийдвэрлэсний дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендер шалгаруулалтыг хийсэн. Улмаар олон улсад нэр хүнд бүхий **“Мүүр Аудит” ХХК-тай 2023 оны 07 дугаар сард гэрээ байгуулсан**. Тус аудитын багийн зүгээс компанийн 2020 оноос хойшхи үйл ажиллагаанд аудит хийж, эхний байдлаар аудитын илрүүлэлтийг ирүүлэн, тайлбар мэдээлэл авах ажил хийгдэж байна.

1. Онцгой дэглэм тогтоосон 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс хойшхи 12 сарын хугацаанд **3.3 тэрбум ам.долларын үнэлгээ бүхий 32.8 сая тонн нүүрс** борлуулсан. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн борлуулалтын орлого 2022 онд 1.1 тэрбум ам.доллар буюу компани үүсгэн байгуулагдсан цагаас хойш хамгийн өндөр түвшинд хүрсэн ба **компанийн түүхэн 12 жилийн хугацааны нийт борлуулалтын 28%-ийг онцгой дэглэм тогтоосон 12 сарын хугацаанд гүйцэтгэв**;
2. Өмнөх үетэй харьцуулахад **борлуулсан нүүрсний хэмжээ 3.9 дахин, тээвэрлэлт 3.5 дахин, экспорт 2.2 дахин, орлого 3.6 дахин, олборлолт 3.1 дахин** тус тус өссөн;
3. Оны эхнээс 10 дугаар сарын 26-ны өдрийг дуустал 2.8 тэрбум ам. долларын үнэлгээтэй 27.4 сая тонн нүүрс борлуулсан ба үүнээс 1.9 тэрбум ам.долларыг дансанд төвлөрүүлж, Монголбанканд 1.6 тэрбум ам.доллар тушаасан;
4. Нүүрс олборлохоос экспортлох үе шатыг ил тод болгон энэ онд төсөвт 2.3 их наяд төгрөгийн татвар, хураамж төлсөн;

СЭДЭВ 7. ПРОЦЕССЫН ДАХИН ИНЖЕНЕРЧЛЭЛ

Асуудал. Төрийн үйлчилгээ иргэдийн хэрэгцээ шаардлага, орчин үеийн нөхцөлд нийцэн хангалттай сайжрахгүй байна.

Төрөөс үзүүлж буй олон төрлийн үйлчилгээ, холбогдох дүрэм, журмууд нь иргэдэд хүндрэл учруулах, төрийн байгууллага, төрийн албан хаагчдад дахин дахин хандах, улмаар тодорхойгүй байдлыг бий болгож бухимдал үүсгэх тохиолдол цөөнгүй байна.

Цаашилбал үйлчилгээ үзүүлж буй төрийн албан хаагчид дарамтад орох, ажилдаа сэтгэл дундуур болох, улмаар иргэдэд уур бухимдлаа гаргах зэрэг ноцтой үр дагаврууд гарч байна.

Иргэдэд үзүүлж буй үйлчилгээг ойлгомжтой, тодорхой, чирэгдэл бага болгох боломжийг судлах, нөгөөтээгүүр төрийн албан хаагчдын ажлын ачааллын тэнцвэрийг хангах, шударга байдлыг нэмэгдүүлэх зорилготой цогц шинжилгээ хийж, арга хэмжээ авах шаардлага байна.

Шийдсэн:

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд процессын дахин инженерчлэлийн судалгааны ажлыг гүйцэтгэсэн. Уг шинжилгээгээр зөвхөн нэг яамны хувьд чиг үүргийн давхцалтай 65 үйлчилгээ, сайжруулах шаардлагатай 1000 гарам процесс байгааг олж тогтоосон.

Ач холбогдол

Үр дүнд нь үргүй зардал, нөөцийн буруу хуваарилалт, төрийн албан хаагчдад ирэх дарамт, бухимдал багасах бол иргэний хувьд ойлгомжгүй, тодорхойгүй байдал арилах, үйлчилгээгээ түргэн шуурхай авах, шат дамжлага багасах боломж бүрдэнэ.

СЭДЭВ 8. ДОТООДЫН АГААРЫН ТЭЭВЭР

Асуудал. Дотоодын нислэгийн үнэ тариф хэт өндөр байсан

Өнгөрсөн хугацаанд дотоодын авиа компаниуд уул уурхайн салбарын захиалгат нислэгүүдэд анхаарч ирсэн нь орон нутгийн хуваарьт нислэгийн үйл ажиллагааг 2 дугаарт тавих нэг нөхцөл болсон байсан. Цаашлаад өрсөлдөөн хязгаарлагдмал байснаас шалтгаалан хуваарьт нислэгийг цөөлөх, захиалгат нислэг үйлдэх замаар үнийг өндөр байлгах бодлого баримталж ирсэн байдаг.

Орон нутгийн нислэгийг тогтмолжуулах, улмаар үнэ тарифыг бууруулахад нэг бол компаниудад улсын төсвөөс дэмжлэг, татаас, татварын хөнгөлөлт үзүүлэх эсвэл шинэ өрсөлдөгчийг зах зээлд нэвтрүүлэх шаардлагыг авиа компаниудын зүгээс тавьж байсан.

Иргэд, жуулчдын хувьд урьдчилан төлөвлөх боломжтой, үнэ тарифын хувьд авто тээвэртэй өрсөлдөхүйц, байнгын тогтмол орон нутгийн нислэгийг бий болгох нь чухал байсан юм.

Шийдсэн:

Монгол Улсын Засгийн газраас орон нутгийн хуваарьт нислэгүүдийг сэргээх, үнэ тарифыг бууруулах асуудлыг судалж үзсэний үндсэн дээр МИАТ компанийг орон нутагт нислэг үйлдүүлэх, дотоодын авиа компаниудтай өрсөлдүүлэх шийдвэр гаргасан.

Засгийн газраас баримталж байгаа гол чиглэл бол орон нутгийн нислэгийг тогтмолжуулах, иргэдэд сонголтыг бий болгох, түүнчлэн аялал жуулчлалыг хөгжүүлэх юм.

Цаашид орон нутгийн нислэг үйлдэх сонирхолтой авиа компаниуд чөлөөтэй өрсөлдөх, энэ салбарт орж ирэхийг Засгийн газраас дэмжих бодлого баримтална.

Ач холбогдол

Орон нутгийн нислэгийг сэргээж 2023 онд 8 чиглэлд 423 мянган зорчигч тээвэрлэлээ. Олон улсын болон дотоодын нислэгийн тийзний үнэ 2-3 дахин хямдарсан.

СЭДЭВ 9. ШҮҮР АЖИЛЛАГАА

Асуудал

Төрийн бүх шатны байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх хууль бус томилгоо.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолоор 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарлаж, Ерөнхий сайдын 2023 оны 49 дүгээр захирамжаар авлигатай тэмцэх 5Ш буюу “Шүгэл, Шүүр, Шувуу, Шилжүүлэн авах, Шил” ажиллагааг хэрэгжүүлж ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгосон.

Шийдсэн:

Төрийн бүх шатны байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, улсын үйлдвэрийн газар бүр “Шүүр” ажиллагааны хэрэгжилтийг хангаж, 11 чиглэлээр хууль тогтоомж, холбогдох шаардлагыг зөрчиж томилогдсон этгээдийг олж тогтоон, 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөр тасалбар болгон хуульд заасан журмын дагуу ажлаас чөлөөлөхийг чиглэл болгосон.

Төрийн бүх шатны байгууллагад өөрсдийн нөөц бололцоонд түшиглэн байгууллагынхаа хэмжээнд “Шүүр” ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагыг дээр дурдсан чиглэлийн хамт өгч албан бичгээр 3,618 байгууллагад хүргүүлснээс 3,387 байгууллага хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, мэдээг ирүүлсэн.

Энэхүү “Шүүр” ажиллагааны үр дүнд **3,387 байгууллагын 3159 албан тушаалтанд хамаарах** нийт 6278 зөрчил илрүүлсэн бөгөөд үүнээс 481 албан тушаалтныг үүрэгт ажлаас чөлөөлж, 1334 албан тушаалтанд чөлөөлөх мэдэгдэл хүргүүлж, бусад 1344 албан тушаалтны зөрчлийг арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан.

“Шүүр” ажиллагааны үр дүнд зөрчил илэрсэн 3,159 албан тушаалтны 1815 буюу 57,4 хувь нь үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хэмжээний зөрчилтэй болохыг тогтоосон байх бөгөөд үүнээс өнөөдрийн байдлаар 481 албан тушаалтныг чөлөөлсөн байна.

Ач холбогдол

Төрийн албаны тухай болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, төрийн бүх шатны байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх хууль бус томилгооны асуудлыг нэгдсэн байдлаар цэгцэлсэн.

СЭДЭВ 10. СУДАЛГААНЫ НЭГДСЭН САН

Асуудал. Төрд хийгдсэн судалгаа, шинжилгээний ашиглалт хангалтгүй

Төрийн байгууллагууд жил бүр судалгаа, шинжилгээнд хөрөнгө оруулж байгаа боловч түүний үр дүн, дүгнэлтүүд төрийн бодлого шийдвэрт хангалттай ашиглагдахгүй байна.

Шийдсэн:

Судалгааны нэгдсэн цахим санг хөгжүүлж, өмнөх хугацаанд хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлуудыг нэгтгэсэн платформыг 2023 оны 06 дугаар сард ашиглалтад оруулсан.

2024 оны 01 дүгээр сарын байдлаар www.sudalгаа.gov.mn сайт дээр Монгол Улсын яам, агентлаг, аймгийн ЗДТГ тэргүүтэй 77 байгууллага дээр бүртгэл үүсгэж, төрийн төсвөөр хийгдсэн 1,000 гаруй судалгаа шинжилгээний ажил нэгтгэгдэж, олон нийтэд нээлттэй байршаад байна.

Ач холбогдол

Төрийн бодлого, шийдвэр судалгаа, шинжилгээнд илүү суурилах;

Өмнөх хугацаанд хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлыг байгууллага харгалзахгүйгээр ашиглах, цаг хэмнэх.

СЭДЭВ 11. ОРАНО

2023 оны 10 дугаар сарын 12-нд Хөрөнгө оруулалтын гэрээний хэлэлцээний протоколд гарын үсэг зурсан.

Франц Улс ТЭЗҮ-ийг боловсруулсан. 30 жилийн хугацаанд 4.5 тэрбум ам.долларын цэвэр ашигтай байна гэсэн тооцоолол гарсан. Энэ үнийн дүнгээс 1.6 орчим тэрбум ам.долларыг Монгол Улс АМНАТ хэлбэрээр авахаар байгаа.

Хөрөнгө оруулалтын хэлэлцээг амжилттай хийж дуусгавал Монгол Улс нийт дүнгээрээ 3.2 тэрбум орчим ам.долларын орлогыг татвар, АМНАТ, ногдол ашиг хэлбэрээр хүртэх боломжтой гэсэн анхны тооцоо гарч байгаа.

12 дугаар сарын 01-нээс “Орона майнинг” компанитай хэлэлцээ эхэлсэн. Хэлэлцээнд дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө авах үүднээс олон улсын зөвлөх үйлчилгээний компани авч ажиллуулж байна.

Хэлэлцээ хийхтэй холбоотойгоор 6 ажлын дэд хэсэг байгуулагдсан.

Эдгээр дэд хэсгүүд Татвар, санхүү, Эдийн засаг, хөрөнгө оруулалт, Олборлолт, үйлдвэрлэл, технологи, Байгаль орчин, орон нутаг зэрэг чиглэлүүдээр хэлэлцээ хийж байна.

Хөрөнгө оруулалтын гэрээ учир асуудал бүрийг деталь тохиролцож байгаа тул хугацаа авч байна. Хэлэлцээний ширээн дээр нийт 224 асуудал байгаа бол өнөөдрийн байдлаар 115 асуудал дээр тохиролцоонд хүрээд байна.

Хөрөнгө оруулалтын гэрээний хэлэлцээг 2024 оны 03 дугаар сард эцэслэх төлөвлөгөөтэйгөөр ажиллаж байна. Улмаар хөрөнгө оруулалтын гэрээг УИХ-д өргөн мэдүүлж шийдвэрлүүлнэ.

СЭДЭВ 12. ДОПИНГ

Асуудал. Дэлхийн допингийн эсрэг байгууллагаас Монгол Улс олимпод цагаан тугийн дор орох эрсдэлтэй байгааг сануулсан

Дэлхийн допингийн эсрэг байгууллагаас холбогдох дүрмийн дагуу Нийцлийн хяналтын асуулгыг 2022 оны 01 дүгээр сард 1 дүгээр зэрэглэлийн 50 орон, 5 дугаар сард 2 дугаар зэрэглэлийн 30 оронд явуулсан. Монгол Улс нь тамирчдынхаа тив, дэлхийн амжилтаас шалтгаалан 2 дугаар зэрэглэлд багтдаг бөгөөд нийцлийн хяналтын дүнгээр 2022 оны 12 дугаар сард ноцтой 11, чухал 8, ерөнхий 2, **нийт 21 зөрчил арилгах шаардлагыг ирүүлсэн** байдаг.

Дэлхийн допингийн эсрэг дүрмийн дагуу ноцтой шаардлагыг 3 сар, чухал шаардлагыг 6 сар, ерөнхий шаардлагыг 9 сарын дотор биелүүлсэн байх шаардлагатай байдаг.

Гэвч 2023 оны 09 дүгээр сарын байдлаар **ноцтой 11 шаардлагаас 6-г биелүүлээгүй тул** Дэлхийн допингийн эсрэг байгууллагын Гүйцэтгэх хорооны 09 дүгээр сарын 22-ны өдрийн хурлаар **шаардлагыг биелүүлэх эцсийн 4 сарын хугацааг өгсөн**. Тухайлбал:

1. Шинжилгээний түүврийн төлөвлөгөөг эрсдэлийн үнэлгээнд үндэслэн боловсруулж, баталгаажуулсан эсэх;
2. Шинжилгээний түүврийн төлөвлөгөөнд туссан спортын төрлүүд нь спортын тусгай шинжилгээний техникийн баримт бичигт заасан хамгийн доод шаардлагад нийцэж байгаа эсэх;
3. Тамирчны биологийн паспорт дахь цусны шинжилгээний модулийг хэрэгжүүлэх;
4. Шинжилгээний бүртгэлийн сан дахь тамирчдыг жилд 3-аас доошгүй удаа шинжилсэн эсэх;
5. Шинжилгээний дээжийг зохих хугацаанд лабораторид хүргүүлэн шинжлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж байгаа эсэх.

Шийдсэн:

Ерөнхий сайдын захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж ажилласан. Ажлын хэсгээс Монголын Үндэсний допингийн эсрэг байгууллагын удирдлага, үйл ажиллагаа нь цөөн хүнээс хамааралтай байдлыг арилгах, үйл ажиллагааг залруулах арга хэмжээг богино хугацаанд авч хэрэгжүүлсэн. Тухайлбал:

1. Монголын Үндэсний Допингийн Эсрэг Байгууллагын дүрмийг шинэчилсэн. /Улс орнуудын Үндэсний допингийн эсрэг байгууллагуудад зориулан ВАДА-гаас нийтэлсэн зөвлөмжийн дагуу/
2. 5 хүнтэй удирдах зөвлөлийг 13 болгож өөрчилсөн. /Засгийн газар, Олимпийн хороо, Паралимпын хороо тус тус 2 төлөөлөл, хараат бус 6, тамирчны төлөөлөл 1, нийт 13 хүн/
3. Монголын Үндэсний Допингийн Эсрэг Байгууллага – Биеийн тамир, спортын улсын хороо хооронд хамтын ажиллагааны гэрээ байгуулагдсан. Шинжилгээнүүд хэвийн хийгдэж эхэлсэн.
4. Ил тод байдлыг дүрэмд тусгасан.

Улмаар дээр тавигдсан шаардлагыг 3 сарын хугацаанд багтаан бүрэн биелүүлсэн.

Ач холбогдол

Монгол Улс дахь допингийн эсрэг үйл ажиллагаа олон улсын жишигт нийцэх, цаашид түүнтэй холбоотойгоор үүсэх эрсдэл буурна.

---oOo---